



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Шинжлэх Ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.4.2 дахь заалт, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн дүрмийн 5 дугаар зүйлийн "е" дэх хэсэг, Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгчийн 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А/95 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсгийн боловсруулсан саналыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дотоодын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталсугай.
2. Шалгуур үзүүлэлтийг баталсан өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг ШУА-ийн хүрээлэнгүүдийн захирал, Бүтцийн төрөлжсөн академи, Бага чуулганы дарга нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ШУА-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга (академич Б.Авид)-д даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Д.РЭГДЭЛ

ДОТООДЫН МЭРГЭЖЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛД
ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

	Нийтлэг шаардлага	Шалгуур үзүүлэлт
1.	Сэтгүүлийн нэр, танилцуулга зөрчилгүй ойлгомжтой байх	Товч тодорхой ерөнхий танилцуулгатай байна.Үүнд: -Нэр нь бусад сэтгүүлтэй давхцаагүй байх; -Холбоо барих хаяг, байршил, утас, хэвлэлийн газрын нэр, цахим хаяг зэргийг тодорхой бичсэн байх; -eISSN; ISSN дугаар авсан байх, DOI дугаарын мэдээллийг тусгах; -Жилд хэвлэн нийтлэх давтамж, өгүүллийн тоо, ямар хэлээр нийтэлдэг талаар мэдээлэх; -Хөгжлийн түүхийг үнэн зөв, хураангуй байдлаар тусгаж мэдээлэх ;
2.	Сэтгүүлийн зорилго, хамрах хүрээ тодорхой байх	-Зорилго, хамрах хүрээ, хэвлэн нийтлэх бүтээлийн төрлийг тусгасан байх; -Тухайн сэтгүүлд тохирох, хамаарах бүтээлийг нийтлэх;
3.	Зохиогчид зориулсан зааварчилгаа тодорхой, ойлгомжтой байх	-Хэвлэн нийтлэх тухай зааварчилгаа дэлгэрэнгүй тайлбартай байх; -Хэвлэн нийтлэх бүтээлийн төрөл нь зохиогчид зориулсан зааварчилгаатай нийцсэн байх; -Сэтгүүлийн редакцад өгүүллийн эх бичвэрийг илгээх үе шатыг тодорхой тайлбарлах, цахимаар хүлээн авах эсэхийг тусгаж мэдээлэх; -Хэвлэн нийтлэх ёс зүй, стандарт шаардлагыг дэлгэрэнгүй тайлбарлах; -Олон улсад мөрдөж буй шаардлага, стандартыг дагадаг бол түүний линкийг тусгах;
4.	Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах нөхцөл, тавигдах шаардлагыг тодорхой тусгасан байх; Нээлттэй, хаалттай эсэх. Жишээ нь: © Copyright эсвэл CC "Creative Commons" лицензийн аль нь болохыг шийдвэрлэж, тодорхой заасан байх	-Зохиогчийн эрх, оюуны өмчийн хамтын ашиглалтын эрхийн асуудлыг шийдвэрлэсэн байх; -Оюуны өмчийн ашиглах түгээмэл лицензийн эрхийн асуудлыг (BY; NC; ND; SA) шийдвэрлэж, олон улсад нийтлэг мөрдөгдөж буй шаардлагын дагуу хэвлэн нийтлэх бүтээлийн эхний нүүрэнд заавал тусгасан байх; -"Creative Commons" лицензийн нөхцөлийг дэлгэрэнгүй дурдсан байх ба лицензийн нөхцөлийг HTML/PDF өргөтгөлөөр ашиглагдах боломжтой байдлаар багтаасан байх; -Зохиогчийн эрхийн зөрчил, хуулбарлалт шалгадаг программыг ашигладаг байх;
5.	Редакцын зөвлөлтэй байх	-Сэтгүүлийн стратеги болон редакцын зөвлөлийн бодлоготой байх; -Редакцын зөвлөлийн үйл ажиллагаа тогтвортой байх; -Редакцын зөвлөлийн гишүүдийн мэдээллийг бүрэн тусгах; (овог, нэр, байгууллагын харьяалал, цахим хаяг) -Редакцын зөвлөлийн гишүүд идэвхтэй байх;

6.	Хөндлөнгийн хянан магадалгаа хийх бодлоготой байх	-Хянан магадалгаа хийх бодлого тодорхой байх; (Хөндлөнгийн хянан магадалгаа хийх бодлогод ил хөндлөнгийн болон далд хөндлөнгийн хянан магадалгааны аль хувилбараар хийхийг тодорхой тусгах; -Олон улсад мөрдөж буй хөндлөнгийн хянан магадалгаа хийх бодлогыг дагадаг эсэхийг тайлбарлах; -Хөндлөнгийн хянан магадалгаа хийх болон санал шүүмж хүлээн авах тогтмол хуудастай байх;
7.	Нийтлэлийн ёс зүй ба хууль бус үйлдлийн талаарх мэдэгдлийн шаардлага, түүнийг зохицуулах, шийдвэрлэх бодлогыг тодорхой тусгах	-Сэтгүүлийн ашиг сонирхлын зөрчлийн бодлого, нийтлэлийн ёс зүй ба хууль бус үйлдлийн талаарх бодлогыг дэлгэрэнгүй тайлбарлах; (Тухайлбал: зохиогч, редактор, шүүмжлэгч, хэвлэн нийтлэгчдэд зориулсан ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах заалтуудыг тусгах) -Олон улсад мөрдөж буй нийтлэлийн ёс зүй ба хууль бус үйлдлийн мэдэгдлийн удирдамж- заавар зөвлөгөөг дагадаг бол түүний линкийг тусган тайлбарлах;
8.	Цахим хайлтын систем, цахим хуудастай байх	Сэтгүүлийн цахим хуудас нь хэрэглээнд нийцсэн дизайнтай, тогтмол ажиллагаатай байх
9.	Цахим архивтай байх	Цахим сэтгүүл нь архивтай байх, өгүүлүүдийг бүрэн эхээр нь холбоосоор оруулсан байх
10.	Хэвлэн нийтлэх хуваарийг тодорхой тусгах	-Сэтгүүлийн жилд нийтлэх давтамжийг заах; -Сэтгүүлийн дугаар бүр нь архивласан дугааруудтай тохирч байх гэх мэт;
11.	Сэтгүүлд хэвлэн нийтэлсэн өгүүллийн хүртээмж	Хэвлэн нийтэлсэн өгүүллийг бүрэн эхээр нь үзэх боломжийг олгох
12.	Өгүүлэл хэвлэн нийтлүүлэхэд шаардагдах хураамжийг тусгах	Хэвлэн нийтлүүлэхэд шаардагдах үнэ төлбөрийн талаар мэдээллийг дурдах, төлбөргүй нийтлэх бол тусгасан байх;
13.	Сэтгүүлийн индексийн талаар мэдээлэх	Сэтгүүлийг нэгээс дээш сэдвийн мэдээллийн санд индексжүүлэх
14.	Орлогын эх үүсвэр буй эсэхийг заах	Сэтгүүл нь зохиогчоос шаардах хураамж, захиалга, сурталчилгаа болон бусад эх үүсвэрийг тусгасан байх

Тэмдэглэл: Дотоодын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухааны сэтгүүлийн олон улсын JPPS (Journal Publishing Practices and Standards) стандарт, нээлттэй хандалтын сэтгүүлийн лавлах (DOAJ)-д ашигладаг агуулгын зарчим, шинжлэх ухааны сэтгүүлийн үнэлгээний хэрэгсэл, шалгуурыг баримтлан боловсруулсан болно.

Энэхүү нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг мөрдөж ажилласнаар хэвлэн нийтлэх ажлын тогтвортой байдал хангагдах, бүтээл нийтлэлийн чанар сайжрах, сэтгүүлийн редакцын зөвлөлийн идэвх санаачилга, хариуцлага нэмэгдэх боломжтой болох юм. Эрдэм шинжилгээний сэтгүүлийн үндсэн шаардлагад нийцэж байж, олон улсад индексжүүлэх, өрсөлдөх боломж бүрдэх тул дотоодын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг сайтар даган мөрдөж ажиллахыг зөвлөж байна.